

**"Алив муу рыг үзэх бичиг" ба  
монгол нүүдэлчдийн, мал амьтны  
муу зуршлаас үүдэлтэй зөн бэлгийн үзэлт**

*Л.Хүрэлбаатар (Монгол)*

Монгол нүүдэлчдийн ахуй амьдрал, зан сэтгэхүйн өвөрмөц онцлогийг тусгасан "Хүний шинж", Тазрын шинж", "Морины шинж", "Зүүдний шинж", "Цаг улирлын шинж", "Эцэг мал тавьж сонгох шинж", "Эрдэнэ таних шинж", "Далны шинж", "Хэрээ шаазгайны хэлний шинж" зэрэг олон зүйл шинжийн судар ном уламжлан ирсэн боловч, өнөө бидэнд нэр нь дуулдаад, огт гарт орж ирээгүй байгаа, шүдний өвчнийг засах монгол аргыг бичсэн "Уйлж ирээд инээж буцах" хэмээгч судар<sup>1</sup>, ус олох, худаг гаргах аргыг бичсэн "Газрын хөх судас" хэмээгч судар<sup>2</sup>, нар, сар, од гаригийн явдал, цас хур, салхи шуурганы байдлыг бичсэн "Цаг улирлын шинж" хэмээгч судар<sup>3</sup>, монгол эм домын элдэв заслыг бичсэн

<sup>1</sup> Тарган бандид Цэвэлванчигдоржийн хийсэн гэдэг "Уйлж ирээд инээж буцах" нэртэй шүдний өвчнийг засах тухай их сонин монгол бичмэл номыг нутгийнхаа Оодон Нацаг гэдэг өвгөнийд байсан Цэвэлванчигдоржийн монгол номын нэг баринтаг дотроос олж үзсэн тухайгаа Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын 4-р бригадын, 1983 онд 60 настай байсан Бадарчийн Цэрэндорж гуай гэж цээж хууч сайтай нэгэн бээр 1985 оны намар цаг надад хуучилсан бөгөөд тэр Оодон Нацагийг нь лавлавал "Хот руу шилжээд удаж байна. Охин нь Хангамжинд бил үү, эмч гэж дуулдсан, сураг тасраад байна" гэснээр миний асуулт тэр тухайдаа мухардаж хожим нь тэр Нацаг өвгөнийг хотоос сурсан боловч эс олсон билээ.

<sup>2</sup> Хотгойд Ахай бэйсийн хошууны Дэлгэрмөрөнгийн хүрээний Рин хамбо буюу "Нийцийн (Нийц зайсан гэж эцэг нь) аграмба багш" хэмээн шавь олондоо алдаршсан Цэрэнжав гуайн төвд хэлээр бичсэн гэдэг, наймт цаасны дөрөв таван хуудас сударчилсан ном, 1946 оны үеэс Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Улаан Самбуу гэлэнд байсан. "Багшийн хийсэн ном" гэж хэлдэг байсныг бодвол лавтай Цэрэнжав хамбынх байсан байх. Бас Самбуу гуай тэр номыг тайлбарлахдаа "Ил худаг гаргахад таарах газрын судас, усны судлын шинж байдлыг бичсэн ном" гэж байсан. Нэг удаа тэр номоо гаргаж үзүүлээд багачууд хүүхэд, бага насны хэдэн хүмүүстэй яриад сууж байсанд Социалист Намсрай гэдэг орж ирээд "Шашны балай суртал багачууд залуучуудад заалаа" гэсэн юм хэлсэнд "Энэ болдоггүй юм бол ...!" гэж хэлэнгүүтээ бүгдий нь хумьж аваад галд шатаачихсан. Түүнээс хойш энэ номыг хэдий асууж суравч өнөө хэр эс олов. Бас "Ачмаг нуурын сан" гэж, "Хужир мараа гарахгүй бол уншиж байгаарай!" гэж Рин хамбын хийж өгсөн гэх сангийн судрыг эрээд олохгүй байна" гэж Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын харъяат, эдүгээ Мөрөн багийн хотгойд өвгөн Ринчинсамбуу гуай надад хуучилсан билээ.

<sup>3</sup> "Цаг улирлын шинж" хэмээх одоогийн цаг агаарын шинжилгээнд ёстой хэрэгтэй нэг монгол ном, арваад цаас, бас би уншиж үзэж байгаад нутгийнхаа Намгилдоржид олоон жилийн өмнө сонирхоод байхаар нь өгчихсөн, одоо ном маань ч. хүн маань ч хаана явааг мэдэхээ больчихоод байна" гэж мөнөөхөн Бадарчийн Цэрэндорж гуай хэлсэн.

Тарнаг дасүм” буюу “Цагаан, хар, алаг гурав” хэмээгч хар домын судар<sup>4</sup>, Ловон Мигиддоржийн архи тамхины гэм эргүүг дуудаж шүлэглэсэн судар<sup>5</sup>, Равжаа хутагтын мутрын ур гэдэг жаран дөрвөн эрдмийн арга мөрийн өнгөт зургийн цомог<sup>6</sup> зэрэг чухамхүү монгол нүүдэлчний уугуул соёлын үнэ цэнэтэй өв, судалгаа шинжилгээний олон нийтэд нэр гарч сураг дуулдалгүй өдий хүрэв. Эдгээрийн дотроос миний бие өмнөх “Монгол нүүдэлчид ба өнөөгийн бэлчээр ашиглалт” сэдвийн хүрэн доор хийсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлаар, монгол газрын

<sup>4</sup> Тарнаг дасүм” гэж хар домын их зузаан, том монгол судар байсныг их эрт харсан юм. Хойно нас ахихад хэрэг болно гэж огт санасангүй. Одоо хүртэл эрж сураад гар дороо авч үзэж чадахгүй байна” гэж 1983 оны хавар цаг, 86 настай байсан, Дорноговь аймгийн Өргөн сумын Лувсандорж гуай, мөн 1983 оны намар цаг, Өвөрхангайн Гучин-Усын Бадарч гуай нар намайг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиол, хуучны ном судар сурвалжлан цуглуулах шинжилгээний ангиар явж байх үес асууж сураглаж байсан.

<sup>5</sup> Манай эндхийн “Хадатын Ловон” ч гэдэг, Ловон Мигиддорж ч гэдэг, түүний хийсэн “Архи тамхины нимиг (гэм эргүү гэсэн төвд үг)” гэдэг арваад цаас монгол судар, архи тамхины гэм, архичин тамхичны хоригийг их дуудан шүлэглэсэн зохиол байсан, одоо бүр олдохоо больжээ. Миний нас залууд уншиж цээжилснээр бол зарим мөр бадгууд нь ийм байсан шиг санагдаж байна.

“Тохисан бурхныхаа

Аравнай шүншгийг арилтал

Ар өврөөс нь утаад

Танилынхаа нөхрийг

Танаг болтол хэлээд

Тамхиныхаа хогийг

Алга болтол гүвээд

Унасан унааныхаа

Ус хөлсийг цувуулаад

Уушги зүрхээ хэлбийтэл давхиад

Уршигтай явдал боллоо гэж

Ажиг ч үгүй суудаг танаа, олон буй заа-гэж байдаг байсан” хэмээн мөн Бадарчийн

Цэрэндорж гуай хуучилсан юм.

<sup>6</sup> Аргын зэндмэнийг, билгийн бадмад учруулах арга, эр эмийн хүсэл эдлэхийн 64 эрдмийг өнгөт монгол зургийн аргаар зурж үзүүлсэн, угтаа 64 зүйл байснаас эдүгээ 25 нь үлдэж хоцорсон, тэр үлдсэнийг нь ажиглавал төвдийн гүймэг шараар таталган бичсэн товч тайлбартай, нэгийн дээр нь бичсэнийг төвдөөс нь орчуулбал “Сав төгөлдөр нүгүүд сайн ажиглаж үз. Сав бус нугуудаас сайтар хориглон нуу! Нуу, нуу, тангараг маш хатуу!” гэж бичсэн байсныг миний бие 1990-ээд оны дундуур Дорноговь аймгийн Равжаа судлалын музейн нууцын хөмрөгөөс олж үзсэн билээ. Угтаа эл зургууд нь хуучны цагт Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн нууцын сүмд машинд эрхэмлэн хадгалагдаж байсан бөгөөд 1937 оны үеэс Дотоод албаныхан, орос цэргүүд лам нарыг барьж, сүм дуганыг хайлуулж байсанд, хийдийг идэж, сүмийг шатаахын урьд шөнө нь нууцын сүмийн тахилч лам Түдэв, Хутагтын хамаг эрхэмд үзсэн гол төлөв бурхан тахил, Хутагтын хувцас баринтаг сэлтийг тэмээнд ачин сэм нууцаар авч гаргаад, жараад жил говийн элсэн дор дарж байлгасаар 1990-ээд оны ардчиллын их салхи сэвэлзэхэд сая хөрснөөс нь задалж, хүүршсэн агаарт нь салхи оруулсанд оп гэмтсэн сэвтсэн зүйлгүй, цагийн эрсдлийн үед ном юмыг булж нууж хадгалах эртний нүүдэлчний аргыг бас ч мэдэж байсан, энэ хашир өвгөний ухаан, уйгагүй хичээлийн ачаар бүрэн биш гэхэд тал нь үлдэж өнөөг хүрч ирсний ач буян их. Чингэж авч гарсан ном зүйлийн юман дотроосоо нэг шоголтойг нь өөрийн гэртээ гар дороо авч байсны нь 1950, 60-аад оны үеэс “арван гэрийн ухуулагч”, “аймгийн төлөөлөгч” хэмээх ардыг ардаар нь цагдуулж, цагдсаны нь цаана цагддаг байсан нууц тогтолцооны үес, Түдэв өвгөнийд ийм нэгэн садар самууны сонин хачиин зургууд байгаа тухай сонирхуулах, мэдээлэх хоёрын дундуур тэнэж явсан үг, нүд чихийг ямагт хуучны сурталтныг мөшгөж мөрдөх хугацаагүй албанд боол мэт зарж сурсан, тэр үеийн аймгийн үзэл суртлын албаныхны хэн нэгэнд хүрч, тэр даруйд нэгэн ширүүн эр шуугин ирж, Түдэв өвгөний бурхан тахил, ном судрыг онгичин сандаргаж, чингэтэл өнөө олон зургууд нь шогол дотроос асгарсанд, аймгийн төлөөлөгч өнөө зургуудыг нь хураах, өвгийнйг барих хориход хүрсэнд, Түдэв өвгөн айхын эрхэнд аймгийн төлөөлөгчийн гарч баримт үлдээхгүйн эрхэнд, өнөөх зургуудыг асч байсан галтай зуухныхаа ам үхээг рүү цацаж орхисонд ихэнх нь улаан галд орж нэгэн хэд нь гадуур ойчиж унасанд, тэр хоёрын загнах зандрах хэрүүл дундуур өрсөн самбаачилж, гэрийнхэн нь сэм түүж аваад хойш нь авч хадгалсан нь дээр миний өгүүлсэн тэр 25 зураг болой.

шинжийн нэгэн зүйл судраар тусгай илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн<sup>7</sup> бөгөөд эдүгээ Төв Азийн нүүдлийн соёл иргэншил дэх монгол нүүдэлчдийн иргэншлийн түүхэн зохицол, оюуны дэвшлийг бүрнээ харж болох, монгол нүүдэлчний мал амьтны этгээд авир араншингаас үүдэлтэй ёр бэлгийн үзэлтийн чухал дурсгал - “Алив муу ёрыг үзэх бичиг оршвой” хэмээх үүнийг<sup>8</sup> эх бичиг, сурвалж судлалын үүднээс нь задлан шинжилсэн юм.

Энэ бичигт нэгд, морины ааш араншингаас болох муу ёр<sup>9</sup> бэлгэ, 14 зүйл: (1. Морь сүрэггээ үргэлж янцгаах, 2. Морь гэнэтэд явтлаа эзний биеийг зуух, 3. Морь эзний дээл хувцсыг зууж хайлах, 4. Морь ус өвс үл идэн, үл уун нулимс цувруулах, 5. Морь хороон дотроо өөсөөн (өөрөө аяндаа) үхэх, 6. Морь ихэр төрөх, 7. Морь унахын урд нэг хөлөө товших, 8. Морины сүүл мөр дор орох, 9. Морь үнээний дээр авирах, 10. Агт морь гүүнд авирах, 11. Морь, үхэр хоёр уулзан явах, 12. Морь дөрөө үзэх, 13. Унасан морины хамраас цус гарах, 14. Агт морь сүүлээ хүйсний дор оруулах): **хоёрт**, үхрийн ааш араншингаас болох сайн муу ёр бэлгэ 12 зүйл: (1. Үхэр гэрт авирах, 2. Үхэр хонинд авирах, 3. Үхэр гэр мөргөн явах, 4. Үхрийн биенээс цус гарах, 5. Үхэрт эзэн нь зуугдах, 6. Үхэр гэнэт эзний эсрэг нулимс гаргах, 7. Хүмүүний дэргэд үхэр хайлах, 8. Үхэр гэнэт хэвтэшний дотор өөсөө үхэх, 9. Үхэр өвс, ус үл идэн, хэвтэн явах, 10. Нүүж явтал үхэр газар малтан мөргөх, 11. Тугал төрвөөс хөл илүү гарах, 12. Үхэр үхэж эс байх): **гуравт**, шувуунаас болох сайн муу ёр 6 зүйл: (1. Шөнө унтсаны хойно гэрийн дэргэд шувуу олноор цуглаж, гэрт орох, 2. Улмаар хайлан гайлах, 3. Гэрийн дэргэд ууль шувуу донгодох, суух, 4. Хэрээ, шаазгай гэрт орох, 5. Шувуу гэрийн дээвэр дээр тэмцэн хэрэлдэх, 6. Аливаа шувуу хүмүүний биед сангасаа сарих): **дөрөвт**, нохойноос болох сайн муу ёр бэлгэ 39 зүйл: (1. Нохой улих, 2. Гэр улсын нохой тэрс хуцах, 3. Нохой хүр хүр хуцах, 4. Нохой дорно зүг хандан хуцах, 5. Гэр зуурын нохой байн байн гаслан бархирах, 6. Нохой гэрийн дээр гарах, 7. Нохой хүний биед авирах, 8. Гэр дор авирах, 9. Нохой голомт дээр хэвтэх, 10. Нохой хаалганы дор идээний сав дор шээх, 11. Нохой эмээл хазаар дор шээх, 12. Нохой ширээн дор шээх, 13. Нохой хүний хувцас идэх, 14. Нохой ширээн дээр бөөлжих, 15. Нохой ширээн дээр хэвтэх, 16. Нохой тогоо, тулга дор шээх, 17. Нохой гэрийн хүнээ зуух, 18. Нохой хөсөгний дотор орох, 19. Нохой голомтонд хэвтэх, 20. Нохой гэнэт өвчин хүртэж үхэх, 21. Нохойн эдгэх, 22. Нохойн нүднээс нулимс цуврах, 23.

<sup>7</sup> Л.Хүрэлбаатар. “Барсын нуруувчит бичиг” хийгээд монгол нүүдэлчдийн бэлчээр шинжих ухаан.-МУИС. Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг. Боть XV (160). XXIII дэвтэр. УБ.2000. 163-174.

\* Aliba mayu i ru-yi üjekü bicig o gosibai: Зузаан шар цаасан дээр нүүр болон эхний хоёр талыг шунхаар, бусдыг хар бэхээр бичсэн хулсан үзгийн бичиг. Цаасны хэмжээ: 22x8,2см. Бичмэлийн хэмжээ: 20.5x7.5 см. Хуудас 6. Нэг хуудаснаа 20-25-аар мөрлүүлж бичсэн. Эл судрыг миний бие 1998 оны намар цаг Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 1 дүгээр багийн харъяат Даарий мужаан хэмээн нутагтаа нэрлэгдсэн, хуучны монгол ном их цуглуулж уншдаг, бас ч сайн муу ёр билгийн юм мэддэг болсон гэлцдэг нэгний, ар гэрээс олж авсан юм.

<sup>9</sup> Ер, ёр (iru-a) гэдэг нь юмны сайн муу, бүтэх эсэхийн урьдаас сэрэгдэх тэмдэг, өөрөөр хэлбэл ямар нэгэн хэргийн сайн муу болохын тэмдэг урьдаас сэрэгдэхийг хэлнэ хэмээнэ. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар. 1966.236. Бас төвдөөр “Itas” гэдгийг “iru-a”, “sovin”, “civil” хэмээн орчуулах бөгөөд төвдөөр “Itas ngan” гэдгийг монголоор “madu iru-a”, төвдөөр “Itas bzang” гэдгийг монголоор “sayin iru-a”, “beige” гэж орчуулдаг. Сумадирадна. Төвд, монгол дохионы бичиг-нэр, үг утга гурвыг тодруулан, харанхуйг арилгагч зул.-Corpus scriptorum mongolorum. Tomus VI. Улаанбаатар 1959. 866.

Нохой шалтгаангүй хөл өвдгөө сөгдөж явах, 24. Нохой сүүлээ зууж гаслах, 25. Нохой гөлгөө идэх, 26. Нохой хорхой (дур) хүрснийгээ зуун, гэрт орж ичих, 27. Нохой архиран үүдэнд байж хуцах, 28. Нохой гэрт малтах, 29. Нохой үнээ, хонь, ямаа, бас хэвтээ тэмээн дээр авирах, 30. Нохой гэрийн баруун, умар, дорноос харайх, 31. Нохой дээш хандаж, хуцан улих, 32. Нохой дорогш хандаж, улин газар малтах, 33. Нохой уурганы хуйвтай орооцолдох, 34. Нохой хөгнө лүгээ ороолдох, 35. Нохой өөрийн тор лугаа ороолдох, 36. Нохой гэнэтэд шөнө ам хэлийг долоож чихээ сэжин, тэр гэр ба хүмүүнийг сэрээж маажих, 37. Нохойн бие нь хар, тэргүүн нь цагаан, хөл, сүүл нь шар (болсон), 38. Нохой өрөөсөн төрөх, 39. Нохой нэгэн эхт, алив охин нуган нүдгүй төрөх): тавд, алив мал адгууснаас болох сайн муу ёр бэлгэ 9 зүйл: (1. Алив мал нүдгүй төрөх, 2. Нэг толгойтой хоёр биетэй төрөх, 3. Нүдгүй өмхий төрөх, 4. Үхэр, хонь, ямаа гэр мөргөн явах, 5. Тэмээ гэнэт буйлах, 6. Тэмээ ирж хайлах, 7. Алив малын биенээс цус гарах, 8. Алив адгуусан дутуу хөлтэй, толгойгүй, биегүй, хагас толгойтой төрөх, 9. Алив адгуусан ороолдох) нийт 80 гаруй зүйл ёр бэлгэсийг дурдаж, тэдгээрт муу зүйл **хэдийд болох нь**: “долоо хоног”, “хоёр долоо хоног”, “гуч хоног”, “жаран өдөрт”, “зуун өдрийн зуурт”, “есөн сард”, “таван оны зуурт”, “арван хоёр оны зуурт”: **хэнд болох нь**: малын эзэнд, гэрийн эзэнд, гэргий, эм хүмүүнд, эцэг эхэд, үр хөвгүүнд, боол зардсанд, эд юмс, мал сүрэгт, эсвэл хаан хатны биед, **юу болох нь**: үхэл зовлон, өвчин ад, гай зэтгэр, тотгор, хэл ам, нус нулимс болох, алиа орох, егүүтэх, хагацах ерөнхий санааны дор: олз олбор гарах, сүрэггүй болох, хорт дайсан учрах, хүнтэй хэрэлдэх, мориноос унах, улайх, морь зовох, унасан морь адуу үхэх, айх ширвээдэх, тэрс идээнд учрах, үг зарах, дайсан болох, цуу хов, алиа болох, эр эм хоёр хагацах, гэргий сэтгэл барах, цус, чөтгөр үзэгдэх, цагт харшлах, хулгай их болох, их хөлчин болох, хаан хүмүүний засаг зарлиг болох, улсад өлсгөлөн болох, их цэрэг хөдлөх сэлт алив муугийн сацуу, бас “дунд сайн”, “сайн”, “маш сайн”, “өлзийтэй сайны” зүйл: олз олбор болох, баяжих, асрах сургахын сайн үйл болох, бие мэнд явах, ургийн хүнээс сайн хэл ирэх, хааны итгэлт нөхөр болохын зүйлийг өгүүлж, бас нэгэнд сайн, нөгөөд муугийн ёр бэлгийг ч дурдсан байна. Нөгөөтэйгүүр эл бүх муу ёр бэлгийг буцааж хариулах, ерөндөг даруулгын зүйл нь: гай золиг гаргах, муу ёрын ном унших, тухайн муу ёр үзүүлсэн үхэр, адуу, тэмээ малыг сүргээс байлгах, саднаа өгөх, эсвэл үтэр бүрэлгэх, нохойг манлай сүүлий нь түлж бусдад өгөх, бас заримд гайт зүйлийг ном унших лам багшид өргөх зэрэг уг гэрийн малд болон маллагч эзэнд тохирсон арга засал хийхийг заасан байна. Бүр хожуугийн үес Бурханы шашны зан үйл болох муу ёрын ном унших, Хаянхирва бурхны хөлөг түм унших, “буу”<sup>10</sup> хэмээх хаалт хариулгын үзгийг зурж бичиж наах, дэлгэх, хоёр бичиг зурж хаалган дээр наах, өврийн Сундуй уншуулах тухай хариулгын зан үйлд өгүүлсэн байна. Хамгийн сонирхолтой нь эл монгол “Ёрын бичиг” Монгол, Төв Азийн улс үндэстнүүдийн дунд эртний байсан хар домын зан үйл, арга засал, хожмоо, бүр сүүлдээ Бурханы шашны гүрэмийн зан үйл болж ирсэн үе цагийн үзэл санаа, шашин, зан үйлийн үе судал харагдаж байна. Жишээ нь: унасан морины хамраас цус гарваас түүний муу ёр бэлгийг хариулах аргад тэр морины хамрын цус, манлайн цусыг авч

<sup>10</sup> “Буу” (buu) хэмээх нь алив муу ёрыг хаах хариулах дом шившлэгийн дүрст үзгийн зүйл. Эл сударт “aliba oroyalduysan mayu iru-a-yi qariyulqu buu”, “aliba noqai-yin mayu iru-a-yi qariyulqu buu”, “ger quduy aliba usun jqqükü saba bügüde-yin buu”, “mori üker-ün mayu iru-a-yin buu” хэмээх дөрвөн зүйл “бууны” дүрс үзэг оржээ.

таван мод хийж, тэр хүний гуталд хийж, алаг утсаар ороож, ураг зүг гарган, улаан хонь цагаан тахил (дээл!) өгөх: агт морь сүүлээ хүйсний доор оруулбаас нэг модон хүн хийж, долоон хэсэг шерөмс, бүргэд өдөт шунхат сум, гурван өнгө торго, алт, мөнгө, цасан гурван зоос болон цулбуур жолоо гаргах: үхэр гэрт авирваас нэг эсгий хүн хийж, илд жад, таван өнгөт хив, есөн алтан торго, есөн өнгө цаас, хар эд дорно зүг гаргах: үхэр үхэж эс байваас гурван барс хийж голомтон доороо булах, гэрийн дэргэд ууль шувуу донгодвоос сууваас, цаасаар шувуу хийж, барсын арьс, цагаан морины дэл модонд өлгөж, хар үхрийн чихний цус эднийг бэлдэж, дорно зүг гаргах, аливаа шувуу хүний биенд сангасваан сариваас есөн хэсэг түүхий мах, улаан дээл, есөн алд торго, таван өнгө цаас, нэг аяга элдэв идээ хийж, шувууны үүр үс, сангасыг улаан моринд ачиж, дорно зүг мянган алхах газар хүргэж орхих, бас гардийн нэр бичиж биенд нааж, гурав хоноод дорно зүг усанд орхих: нохой хүний биенд авирваас цаасаар нохой хийж, үнэгний арьс, цагаан торго, нэг аяга ус, арван хэсэг утсыг чимэж гаргах, буу бичиж хариулах: нохой дорогш хандаж улин газар маажилбаас шар цаасаар хүн мал хийж босгон дор төө сөөм ухаж булах: нохой гэрийн алив зүгээс түлхвээс тэр зүгээс зуун цаас, зуун гурван моголцог шавар хийж гаргаж булах: нохой хөгнө лүгээ ороолдвоос хоёр, хар цагаан балин хүнийг цагаан дээсээр хүлж гаргах, хүрэн морь, хар үхэр, ямаанд хувчид золиг өгч гаргах, буу, балин, хүмүүн хийж гаргах: тэмээ гэнэт буйлваас, бас бас буйлваас улаан халзан үхэрт есөн зүйл идээ, есөн сараху ?, есөн хар цаас, есөн хар чулуу, есөн хэсэг шар шороо үхэрт ачиж урд зүг явуулах, хонь, тэмээгээ сухай ташуураар үлдэн хөөх: алив адгуусан ороолдвоос тэр хоёр адгуусыг гурилаар үүдэн (хийж), хоёр суганд нь чучил хавчуулж, бөгсөнд нь хувцсыг нөмөргөж, эцэг өвгийн нэрийг нэрлэн, "Энэ муу ёрыг эцэг өвөг ав!" хэмээн гаргахыг өгүүлсэн байна.

Эл монгол "Ёрын бичиг" үхрийн олон зүйл авир араншинг сайн муугийн бэлгэ зохион өгүүлсний дотор "Үхэр, бус адгуусны дуугаар хайлан мөргөн гэр тэргийг тойрон явбаас гэрийн эзэнд үхэл учрах, хэл ам болох, /26/ гэх буюу "нүүж явтал, үхэр газар малтан мөргөвөөс хүмүүн өгүтгэх. Үтэр бүрэлгэ... Хүмүүний дэргэд үхэр хайлваас өлзийтэй болох" /3а/ гэжээ. "Монголын нууц товчооны" 121-р зүйлд иймэрхүү муу совин бэлгэ Жамухын явдал дээр гарсныг Зайран тэнгэр нүдний нь өмнө ирж зааж үзүүлснээр, Хорчийн хэлсэн үгэн дотор "Ухаагчин үнээ ирж Жамухыг тойрон явж, Жамухыг ба гэр тэргий нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж солжир эвэртэй болоод "эврий минь өг" гэж Жамухын зүг мөөрч, шороо цацлан байна. Бас нэгэн мухар ухаа үхрийг их гэрт тэргэнд хөллөжээ. Тэр үхэр их тэргүүр (зам)-ээр Тэмүжиний хойноо зүтгэн явж мөөрөн хэлэх нь:

"Тэнгэр газар эелдэж (зөвлөж)  
Тэмүжинг улсын эзэн болтугай гэж  
Тээж хүргэж явна" гэж мөөрнө.<sup>11</sup>

Зайран тэнгэрийн үгээр Жамухад болох ийм нэг муу ёр бэлгийг солжир эвэртэй улаагчин үнээний мөргөж шороо цацлах авир араншингаар, Тэмүжинд болох бас тийм нэг сайн ёр бэлгийг мухар ухаа

<sup>11</sup> Монголын нууц товчоо. Хоёр дахь удаагийн хэвлэл. Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав. Улаанбаатар. 1957. 71

үхрийн мөөрөн хайлах аяг байдлаар хэлсэн нь сайн муугийн ёр бэлгийг үзүүлсэн эл судрын санаатай шууд нийлж байна.

Тэсэрийн туужид” Цотон ноён Сэнлон өвгөнийг эхнэртэй нь гурван голын бэлчирт гайд гарган цөлөхдөө цоохор тэмээ цоохор ботготой, цоохор гүү цоохор унагатай, цоохор үнээ цоохор тугалтай, цоохор хонь цоохор хургатай, цоохор ямаа цоохор ишигтэй, цоохор нохой цоохор зулзагатай, хэлтгий хар цачиртай гаргадаг<sup>12</sup> нь алив ёр муугийн бэлгэ шинжийг хаах хорих арга заслын зүйлд аль олон өнгө шинж, аль олны үс зүс холилдсон алаг булаг хар муу юмаар этгээд мууг хуурч аргадахын санаагаар, чингэж эл монгол “Ёрын бичигт” өгүүлсэн “гурван өнгө”, “таван өнгө торго”, “есөн өнгө цаас”, “эрээн алаг дээс”, “олон өнгө утасны” тасархай өөдөс зүүдэс, үйрмэг зүйрмэгийг зай болгон оруулж арга дом болгодог тэр уламжлалтай холбоотой байна. Түүгээр барахгүй энэ мэтийн монгол ёр бэлгийн бичиг судрын хар домын маягийн арга заслын зүйлийг цааш боловсруулан авч, бүр шашны гүрэмийн ном болгон бичсэн нь ч байна. Төвдийн Ажа Лувсандамбижанцан монгол бичгийн судар дотор байсан, малын гай гарзыг хаах хар домын нэгэн арга болох есөн цагаан чулуу, есөн хар чулуу, есөн цаасан хүн, есөн замын шороо, есөн хэсэг мах, тулганы дорхи шороо, ор дэвсгэрийн доорхи шороо, есөн хэсэг ширмийг үхрийн эвэр дотор хийж амы нь хар бөсөөр таглан боож, есөн хар алаг утсаар машид сайн хүлж боогоод гай гарлагыг хаах ном уншиж, буруу зүгт нь гаргах шашин зан үйлийн төвд судрыг хийсэн байна.<sup>13</sup>

Нүүдэлчин монголчуудын ахуй амьдрал, зан үйл, шашин шүтлэг, сайн муугийн үзэлт, оюун сэтгэлгээний өвөрмөц онцлог нь дан тусгаар байдалд бус, Төв Ази, дорно дахин, ер өрнө дорнын улс үндэстнүүдийн ахуй амьдрал, оюун санааны нийтлэг хэв шинжтэй дам далд холбоотой юм.

Чингэж мал амьтны этгээд авир араншингаас үүдсэн монголчуудын ёр бэлгийн үзэлтийг тодорхой нарийн илэрхийлсэн “Алив муу ёрыг үзэх бичгийг” монгол, төвд Данжураар уламжлан, хятад хэлнээс төвдөд, улмаар монголд орчуулагдан ирсэн “Үг үл өгүүлэгч амьтны ёр” хэмээх судартай<sup>14</sup> харьцуулан үзэхэд, аливаа амьтны авир араншингаас

<sup>12</sup> Гэсэр. Сонгомол эхийг боловсруулж удиртгал, тайлбар бичсэн академич Ц.Дамдинсүрэн. Редактор Ш.Гаадамба. Улаанбаатар. 1986.20

” Mi phyugs god Kha good thabs bzhugs so/ sog pa'i yig cha las Aqya blo bzang bsTan pa'i rGyal mtsan gyis bris pa'o/ (“Хүмүүн малын гай гарлага, хэл амыг таслах арга оршвой”) Төвд бичмэл. Хуудас 6. Л.Хүрэлбаатарын цуглуулга

<sup>14</sup> Cidayci arsi Garya-bar iru-a-yi teyin böged üjügülügen кетекй (KemegdeKü sasdar) orosibai: -Монгол Данжур. Урлахуй ухааны шастирын аймаг. “Go” (211-р) боть. 167а-217: -Төвд Данжур. Урлахуй ухааны шастирын аймаг. “Ngo” (212-р) боть.

Эл судрын учир өгүүлж, номлохыг амалсан үгийн монгол орчуулгыг галиглавал:  
Gray odus-i uqayci-yin cinadu Kürügsen Cidayci-yin ciyulyan-u degedü Carya-dor Bha gos ris-bar mörgüjü бүрүн. alyaban qamtutqan oyuyata öcibei: tngri-yin nidün tegiilder yeke qatayujil-tu: yeke dalai metü tegüs qubitu: degedü bilig-iyer masi uqayci tere uqayan-i olquy-a Küsemüi: oron boda Kiged ügüi ba: üjügülügen aci ür-e-tü bolqu Kiged Kümün nügüd-ün deyileKüi deyiledeKü ba: tegüncilen naran saran ba: tngri-yin oron: Kiged jabsar yajar-un deger-e: iru-a boluysan-i belgedeKüi ba darui qur-a-yin beige Kiged: cay-un jabsar-un toytaysan sayin mayu ba: naran saran nuyud-un orcin toyurin odun-u sumun unaqui Kiged oyturyui qayaraqui ba: Gandari-yin balyasan ba: yajar KödleKüi-yin iru-a ba: naran-u dürsü KüriyeleKüi ba

бэлгэ шинж зохиож, хүмүүн олны дотор болох ирээгүй цагийн олон зүйл харш сөрөг үзэгдэл үйлдлийг зөгнөн ёрлосон ерөнхий санаа нь энэ хоёр судрын тухайд төстэй боловч, монгол "Ёрыг үзэх бичиг" нь монгол нүүдэлчдийн ахуй амьдрал, аж ахуйн хэвшил, зан үйл, шашин шүтлэг, орон цагийн байдал, аливаа сайн мууг үзэх үзэлт, ёс зүй, оюун сэтгэлгээний өвөрмөц онцлогоос шалтгаалан, тэдний олон зууны ахуй амьдралын үзэлт туршлагаасаа боловсруулсан, тусгай бие даасан, чухамхүү "монгол нүүдэлчний ном" болох нь үзтэл ил нут байна. Тухайлбал, Данжурын дотор уламжлан ирсэн, Гарга аршийн "Ёрын сударт" заан, илжиг, үнэг, гөрөөс, хачир тас, бүргэд, хон хэрээ, ууль, шар шувуу, галуу, галандага, нохой, муур, хулгана, зегий, шумуул, хүрзгэнэ зэрэг дорнын суурин газрын амьтдын тухай голлон дурдаж, морь, тэмээ зэргийг хаяахан тэмдэглэж, тэдний авир араншингийн олон зүйлийг хот балгад, сүм, зам уулзвар, хүү сангийн газар, хүрээ хэрэм, байшингийн хана дээвэр, хаалга үүд, бас лянхуат суудал дэвсгэр, тугийн үзүүр зэв сэлт, хот суурингийн амьдралын орон нөхцөлд, тэр газрын эд юманд холбож, тэдгээрийн муу бэлгэ шинжид хаан эзний үхэх өвдөх, цэрэг дайны аюул болох, хулгай дээрэм ихсэх, хижиг өвчин дэлгэрэх, тариан төмс хомсдох тухай өгүүлсэн бол, монгол "Ёрыг үзэх бичигт" морь, үхэр зэрэг гэрийн малын элдэв авир араншинг голлон олон зүйл нөхцөл байдалд маш нарийн өгүүлж, харин ууль, шар шувуу зэрэг амьтныг тухайлан дурдаж, тэдний этгээд олон зүйл авир араншинг монгол нүүдэлчний ахуй амьдралаас үүдэлтэй, "Морь дөрөөлөн үзэх", "Морь, үхэр ижил сүрэг дотроо янцгаах, мөөрөх", "Үхэр гэрт авирах", "Үхэр, бус адгуусны дугаар хайлан мөргөн гэр тэргийг тойрон явах", "Нохой гэр дээр гарах", "Морь, үхэр, нохой эзнээ зуух", "Ууль, шар шувуу гэр дээр суух" эсвэл "Малын хашаа, уяа шон дээр суух" зэргийг олон зүйл шинжээр нь дэлгэрэнгүй дурдаж, тэдгээрийн муу бэлгэ шинжид гэрийн буюу малын эзэнд, эсвэл тэр айл гэрт үхэл зовлон, нус нулимс, гай зэтгэр ирэх болоход ёрлон шинжсэн байна. Бас монгол "Ёрын бичигт" мал адгуусны эдгээр харш сөргийн гэмийг арилгах, даруулга, ерөндгийн зүйлд, тухайлбал "Унасан морины хамраас цус гарваас тэр хамрын цус,

tegüncilen saran KüriyeleKüi terigüten tedeger бүгүд-i qocural үгөй-e: qatayujil бүтүгсен ciber nomluquy-a jöKistu: teyin Kernен öcigsen-dür yeke jibqulang-tu Carya-bar ene үгес-i ögülebei: Bhagori-e-e ali asyuysan tegün-i sonusuytun qubitan: jula KemegdeKü sastir egün-i: qamuy Kereglegsen-i medegülügci: aldar todurqai Kiged: teyin todurqai ba: jiryal jobal-i mayad onuyuluuci-yi birman-u erKin Kiged qayan-dor degedü arsi-bar üjügülsügei: /167a/ Үүнээ гариг одсын ухааны цаана гарсан Гарга хэмээх аршид. Багори хэмээхээс тэнгэр одны ухааныг олохыг хүсч, мөргөн гуйсанд, "орон бод хийгээд бод үгүй ба үзүүлсэн ач үрт болох хийгээд хүмүүн нүүгүдийн дийлэх дийлдэх ба түүнчлэн нар сар, тэнгэрийн орон хийгээд завсар газрын дээр ёр болсны бэлгэдэхүй... жаргал зовол магад онуулагчийг" бярманы эрхэн хийгээд хаанд дээд их арш Гарга бээр тийн номлох болсныг өгүүлжээ. Гарга аршийн "Ёрыг тийн бөгөөд үзүүлсэн хэмээх шастирын" доторхи "үг үл өгүүлэгч амьтан бүгдийн ёр" хэмээх наймдугаар бүлэгт нохой, хон хэрээ, хачир тас, бүргэд, галуу, ууль, галандага. шар шувуу, заан, үхэр, морь, тэмээ, илжиг, үнэг, гөрөөс, муур, хулгана, могой зэрэг адгуусан амьтдын ёр бэлгийг болох юмны нь үр хаягдалд холбон номложээ. -Монгол Данжур, 211-р боть. 1826-1846. Энэхүү Гарга аршийн ёрын шастирыг төвд Данжурт ч, монгол Данжурт ч орчуулагч ариутгагч нь лозава гүүш хэн, ямар хэлнээс, ямар сурвалжийг түшиглэж, хэрхэн орчуулсан тухайд төгсгөлийн үг огт байхгүй байгаа боловч, харин төвд "Дэргэ Данжурын гарчиг" хэмээх номд "Их чадагч Гарга бээр ёрыг тийн үзүүлсэн хэмээгдэх судрыг хятадаас орчуулсан" хэмээн төвд хэлээр тэмдэглэсэн байна. Энэ тухайн төвд эшлэл нь: Thub pa chen po drang srong Cargas Itas Kyi mam pa bstan pa zhes bya ba'i gtzug lag rgya nag nas bsgyur ba.- bsTan gyur dKar chag/ bzo rig pa'i bstan bcos Kyi sKor/ "Ngo" (212-p) боть. Данжурын гарчиг. Урлахуй ухааны шастирын аймаг. "Ngo" (212-p) боть. mTso sngon, 1985, 836

магнайн цусыг авч, таван мод хийж, тэр хүний гуталд хийж, алаг утсаар ороож, урагш зүгт гаргах" тэргүүтэн монголын эртний хар домын олон зүйл арга заслыг өгүүлсэн байхын сацуу, "буу" хэмээх дүрс үзгийг биед зүүх, муу ёрын ном унших, Хаянхирва бурхны хөлөг түм унших, тухайн юмыг үгүй хийх, гай золигт гаргах, өөр нэгэнд зайлуулах, эсвэл ном уншуулсан ламд өргөх шашин номын арга заслыг ч олонтаа өгүүлжээ.

Монгол "Ёрын бичигт" "Нохой дээш хандаж хуцан уливаас баяжих" ёр бэлгэд үзсэн бол, Гарга аршийн "Ёрын шастирт" "Нохойнууд хурж, дээшид хандаж, бас бас уливаас тэр нь орноо егүтгэхийн ёр болой" гэжээ. Хэдийвээр нэг зүйлийн бэлгэ шинж боловч нэгэндээ сайн нь нөгөөдөө муу, бас ч хятад, энэтхэг, төвд, монголын газар газарт тэр бэлгийг үзэх үзэлт өөр өөр боловсорсныг харуулж байна. Бас адил бус боловч, төстэй мэт юм үзэгдлээс ёр бэлгэ зохиож авсан зүйл буй нь, тухайлбал монгол "Ёрын бичигт" морины хамраас цус гарахыг муу бэлэгт үзсэн бол, Гарга аршийн "Ёрын шастирт" зааны хамрын үзүүрээс цус гарахыг: монгол "Ёрын бичигт" нохой ширээн дээр хэвтэхийг муу харшийн бэлэгт үзсэн бол, Гарга аршийн "Ёрын шастирт" "Хон хэрээнүүд лянхуан навчны дэвсгэрүүд дор наадаж үйлдэхийг" муу ёрд үзэх: бас эдгээр бичиг шастируудын хооронд адилхан үзсэн муу ёр бэлгэ ч буй нь: монгол "Ёрын бичигт" ууль, шар шувууг айл гэрийн дэргэд, хашаа хороонд суух дуугарахыг, Гарга аршийн "Ёрын шастирт" "...үдийн цагт заан хийгээд үхрийн орон ба морины хороонууд дор шар шувуу үзэгдэж, мал нугуудыг унахыг" муу ёрд үзэх үзэлт адилхан байгаа нь элээ, шар шувуу, ууль шувууны чуулганыг энэтхэг, төвд, монголын шашны зан үйлд "бүдсийн шувуу" хэмээн нийдэмд үздэгтэй учир холбогдол нэг юм.

Монгол нүүдэлчид, Төв Азийн улс үндэстнүүдийн ахуй амьдрал, зан үйл, оюун санаа, ухамсрын олон хэлбэрийг гүнзгий тусгасан, монгол "Ёрын бичиг" бол сав орон, шим амьтны үүр орчин дахь алив юм үзэгдэл, түүний дотроос адал мал, амьтан адгуусны олон зүйл этгээд үйлдэл явдлыг, болсон орон зайнд нь, болох цаг хугацаанд нь, илрэн гарч байгаа авир араншин, аяг байдал, дүр төрхөд нь зөн мэдлийн бэлгэ шинж оноож, шалтгаан үрийн ойр хол, ил далд дагалдал холбоог нь байгалийн зөн, "тэнгэрийн нүдээр" урдаас нээн шинжилж, холын тэр далд битүүлэг үр хаягдлын өмнө, чухам тэрхүү "Ёрын бичиг" судрын дотор өгүүлснээр, хүмүүн амьтан, нийгэм олны "орон бод хийгээд бодгүй", "дийлэхүй дийлдэхүй, жаргал зовлыг үзүүлсэн", баларлаг эрт цагаас эдүгээ хүртэл уламжилсан шашин-гүн ухаан, зан үйл, ёс зүй, сэтгэл зүй, оюун зүй, нийгмийн үзэл санааны танилтын чухал дурсгал болно.

Эцэс дээр нь тэмдэглэхэд Сүмбэ хамбо Ишбалжир "Норвү-гэдага" буюу "Тунгалагжуулагч чандмань эрдэнэ" гэдэг алдарт зохиолыг төвд хэлээр бичсэн юм. Түүндээ Бурхан багшийн амны эшийн ариун айлдвар гэх, Ганжурын дотор орсон зарлиг зохиолуудыг чухамхүү Бурхан багшийн айлдвар мөн үү, биш үү гэдгийг нарийвчлан шинжлээд, "Алтангэрэлийн хишиг даллагын судар", "Хонины тогтоол тарни", "Долоон одны судар", "Гариг өвчин бүгдийг амирлуулагч арш эцгийн тогтоол", "Хар хэл амыг амирлуулагч их хөлгөн судар", "Хар хятадын буцаалт", "Цагаан шүхэртийн буцаалт" зэрэг шашин зан үйлийн олон судар тарнийн дотор хятад, төвд хэл, төвдийн малчдын хар яриа холилдсон, энэтхэг, шаншүн, сүмбийн хэл тус тусаас орчуулсан ... алт гурилыг хольсон адил судар тарнид ч бомбын ба төвдийн тарнич хар тэнэгүүдийн чалчаа үгээр



бузарласан ... тарнийн доторхи хятад, уйгур, бус бас энэтхэг, монгол, төвд аль нь ч бус холилдсон хэл... тэргүүтнийг үзвээс... тэр мэтийн уршиг хир халдаагчууд нь төвдийн бомбо, хятадын тарничин, сонсгол доройнуудын судар тарниас авч найруулсан дур зоригийн зарлиг мэт ба хар горьг хураагч мөлжигчин тэргүүтний зохиосон ном мөн буюу... Тэр мэт нь эгэл харчуудын гүрэмд Тахай төлөгчийн сайн зол заяа таарсан мэт” өчүүхэн тус боловч, тэр төдийгөөр итгэж үйлдэлгүй, итгэмжтэй шалгадаг зарлигт шүтэж ариутган шүүх хэрэгтэй” гээд, тэр мэтийг ариутган засахын тулд Сүмбэ хамбо өөрийн эл зохиолыг их далайн булингарыг ариутган шүүдэг норвү-гэдага гэдэг чандмань эрдэнээр үлгэрлэн, Ганжурын доторхи Бурханы нэрээр орсон хуурмаг сэжигтэй зохиолын булингар хирийг арилгах шүүмжлэлийн санаагаар "Норвү-гэдага" хэмээн нэрлэснээ тэмдэглэжээ. Сүмбэ хамбо Ишбалжирын ингэж энэтхэгийн Бурханы ариун номлол Ганжурын дотор хятадын тарничин, төвдийн гүрэмчин, тартигаан тэнгэртэн, малицын бөө нарын уг номлол холилдсон гэж шүүмжилсэн нь нэг талаар энэтхэгийн Бурханы шашны сургаалыг төвдүүдийн буртагласан булингартуулсан хирээс цэвэршүүлэн шүүхийн тухайд шашин номын үзэлтийн талаасаа арга эрхгүй хэлэх үг мөн боловч, нөгөө талаар тэр нь харин Ганжур хэмээх их цоморлиг зөвхөн энэтхэгийн номлолоос гадна хятад, төвд, уйгур, монгол зэрэг Төв Азийн улс үндэстнүүдийн оюуны соёлын асар их зүйлс холилдон нийлснийг батлах үг болж өнөө бидэнд уламжлан иржээ.<sup>15</sup>

Энэ бүгд нь монгол нүүдэлчдийн соёл дахь нүүдэлчний болон суурин газрын, айл өрхийн болон улс гэрийн, өөрийн болон харийн, иргэний болон шашны олон зүйлийн өнгө будаг хэдий холилдон нийлэлдсэн боловч, үндэсний монгол төрх төлөв нь огт алдагдаж гээгдсэнгүй, харин ч баяжин шинэчлэгдсээр ирсэн болохыг харуулж байна.

“Алив муу ёрыг шинжих бичгээс”

Алин сайн ёр төгсөх болтугай!

Гүехэн илтгэлийг минь сонссон нугуудаас

Гүйцэд ухаарал төрөх болтугай!

#### **Aliba mayui iru-a üjekü bicig oro-siba::**

(1r.) Om susti amuyulang boltuyai:: Mori sürüg-tegen (bayi)ju ürgülji incayabasu ejen-düni mayu:: Mori genedte yabutal-a ejen-ü bey-e-i jayu-basu kele ama-‘i ükül mayu beige bui:: Morin ejen-ü debel qubacasun-i jayulan qayalbasu ebecin adan todqar bolqu mayu:: Morin usu ebesü ülü iden ülü uyun nilbusun cubu-rabasu ejen inu ayuydan kele ama ükül jobalang irekü mayu:: Morin qoruyan dotur-a öösben ükübesü jayun edür-ün jayur-a ebecen ükül ucirqu bui:: Morin mori üker ikeri törübesü ejen-ü buyan-a ene mori yai yeke eketei sürüg-tü buu bayly-a:: Mori unu-qu-yin uridan nigen köl-iyen tob-sibasü qoor-tu dayisun ociqu::

(2r.) Morin-u segül emünedü mör-tür orobasu ba mori büü bayly-a:: Mori ünegen-ü degere abaribasü gerün ejen qoyar on-u jayuran ükül ucirqu: qasing morin-u jasal keyilge: cidabasu qayangkeru-a-yin kölge tümen ungsi:: ayatun mori gegüken-dü

<sup>15</sup> Л.Хүрэлбаатар, *Монголчуудын төвд хэлний соёл хийгээд хориг шүүмжийн харуу бичгүүд*. Bulletin. The IAMS News Information on Mongol Studies (Mongyol sudulul-un medegelel). Ulaanbaatar 2000. №1 (25), №2 (26), 14

abaribasü törü-yin ejen mön qoyar-tu mayu: üdtür bürülge:: Mori üker qoyar ayu-lein yabubasu tabun on-u jayura mayu:: Mori dörüge üjekü -anu quluyun-a cay-tu + mayu: üdtür bürülge: üker cay + kümün-lüge kereldekü:: baras + morin-aca unaqu ulayıqu:: tauli + mori jobaqu:: luu noqai + sayin:: moyai yaqai + dumda sayin:: morin + ed mal-du qarsi mayu iru-a-yin nom ungsi:: qonin + ed mal oruqu bey-e metü abıqu masi sayin:: bicen + unuysan mori ükükü:

(2v.) takiy-a + mayu iru-a-yin nom ungsi sayin bolqu:: Unuysan mori-u qabar-aca cisun yarabasu mön tere qabar-un cisun manglai cisun abcu tabun modon kijü tere kümün-i yutul-du kijü alay utasun-iyar oroyaju: uruy (örüne?) jüg yai7-a:: Ulayan qoni ciyan takil Ög:: Ayta mori segül-iyen küisün-ü dor-a oroyulbasu nigen modon kümün kijü doloyan keseg sirmüsü bürged öde-dü singqutu sumun 3 öngge tory-a altan möngge jesün 3 joyos boyon culbur jiluy-a yary-a:: Üker ger-tü abirbasu mön tere Üker-i saday-a ög: mayu iru-a qariyul: nisu nilbusun bolqu: Esegei kümün kijü ildü jida 7 öngge-tü keb 9 alt(d?)an tory-a 9 öngge ciyasun qara ed dorun-a jüg yary-a: yeke jasal kigdekü kereg: Üker qonin-du abirbas? mön qonin-du qarsi: üdter kereg kei:: Üker ger mörgön yabubasu mayu iru-a bui: ger-tür buu nay-a mayu iru-a-yi qariyul:: Üker-ün beyen-ece cisun yarbasu kele ama boluyad: yegüdkekü beige bui:: Üker-tür ejen inü jayuydabasu yeren ödör-ün ükül ada (ende?) bolumji kerber uqabasu buu bicijü nay-a: jasal jasayul: takil yaıy-a: Üker busu adayusun-u dayun-iyar yayılan mörgön ger tergen-i toyorin yabubasu gerün ejen-dür d(j?) ükül ucarqu:: kele ama bolqu:

(3r.) Üker genedten ejen-ü eseregü nilbusun yarbasu yuturcu irebesü ükül adan bolum: jaryu boium:: Sayaqatu kümün-ü deregetü (tergetü?) üker qanilabasu ülicitü (öljicitü?) bolqu:: Üker genedde keb-tesin-ü dotur-a öbesüben ebecin cer kele ama kiged qayacaqu iru-a bolqu:: Üker ebesü usu ülü iden kebten yabubasu ükükü mayu bui:: Negijü yabutala üker yajar maltan mörgöbesü kümün yegüdkekü üdter bürülge:: Tuyul dörben köl ilegüü yarbasu qan-u itegeltü nökor bolqu: duran baraqu (tören bariqu?): Üker ükjü ese bayıbasu 3 baras kijü yolomta door-a bula sayin:: Basa nigen eketü söni untaysan-u qoyin-a kerid dergede sibuyun olan-iyar butan-a ger-tü orobasu sayin:: Eayılan basu mön saradu kümün ükükü: Gereün dergede uyuli sibuyun dongyudbasu ada todqar bui cayasun-iyar sibayun kijü baras-un arasun ciyan morin-u del modon-tur elgüjü qara üker-ün cikin-ü cisun eden-i beledcü dorun-a yary-a buu (büü?) delge sayin:: Keriy-e sanay-a cayai (sayajayai?) gerten orobasu tere gerün kümün-dü ükül jobalang kele ama-tai todqar irekü:: Sibuyun gerün degebür degere temecen kerildübesü yere qonuy-tu kele ama-tai todyar kiged oljan yaraqu:: aliba sibuyun kümün-ü beyen-dü sangyubasu sarıbasu 30 qonoy-tu kele ama cisun

(3v.) tölge irekü: ese bögesü 2 ayan-u (ejen-ü?) jayura ciyulyan nisun nilbusun bolqu:: basa sibuyun ed mal köbegün-tür yeke mayu bui: jasal inü 9 keseg teükei miq-a: ulayan takil yisün alt(d?)a toi7-a: 5 öngge-tü cayasun 1 ayay-a eldeb idegen kijü sibuyun-u egür üsün sangyasun ulayan morin-du acicu doruna jüg mingyan alqu yajar-a kürgejü orki:: yai ügecekü sejeg ügei bui:: Basa bar yarudi-yin nere bicijü sayuysun beyen-dür niy-a:: 3 qonoyad doruna jüg usun-du oraki sayin:: Basa noqai ulıqu-yi üjekü inü: Quluyun-a cay-tu ulıbasu em-e kümün kerildükü: Üker + ayıqu sedkil: Baras + asaraqı suryaqu bolqu: Taulai + sayin: Luu moyai + uruy kümün-ece sayin kele irekü: Morin cay + darasu idegen-dü ucarqu qonin cay-tu ulia-basu gereki sedkil bariqu: Beci takiy-a + yeke sayin: Noqai cay + kele ama bolqu: Taqai + ge jai7u boluyu:: Basa yer ulus-un noqai teresü qucabasu 12 on-u jayura yeke törü-dü

mayu: Noqai kürün kürün qucabasu quluyai yeke bolqu: Noqai doruna jüg qandun + yeke kölçen bolqu: Basa negüdel bolqu: Emüne + dayisun bolqu: Örüne + yeke cereg ködelkü: Ese bögesü adayu-sun sayali degegsi abcü: Umara + adayusun-dur mayu: Ulus-tur ölösküleng

(4r.) bolqu: Basa ger jayur-a-yin noqai bayin bayin yasalang barakirabasu nisun nilbusun kele ama bolqu: Noqai ger degere yarbasu ejen inü ükükü buu bicijü niy-a: Mayu iru-a-yi qara-(i?) yul: Tere noqai-yi busud-tur ög: Noqai kümün-ü beyen-dür abaribasü cuu quu (qob?) aliy-a bui: siroi abacu qayalyan-du nay-a: Tegün-ü degere cuu quu irejü (jiraju?) bicijü: jasutuyai sayin: Ger-tüt abaribasü mayu: Cayasun-iyar noqai kijü ünegen-ü arasun ciyan toray-a 1 ayay-a usun arban keseg utusun-i cimejü: yary-a buu bicijü qariyul:: Noqai yolomta degere kebte-besü yolomta-yin ejen-dür ebecin bolqu:: Noqai qayalyan-dur idegen-ü sabadur sangyabasu olja olqu: Siregen-dür keseg nimekü:: emegel qajiyar-tur sangyabasu olja olqu siregen door-a sangyabasu jiyulcin kümün-dü ebücin bui:: noqai kümün-ü qubacasuni noqai idebesü ükin(ügen?)-dür kele ama bui:: noqai siregen dergeren bögeljibesü Ükin niyun-dur kele aman-u üilen boluyu:: noqai siregen degere kebtebesü adasun-a? qarsilaqu:: noqai toy-a tulyan-dur sigen sangyabasu kele ama bui:: noqai gerün kümün-iyen jayubasu

(4v.) ken kümüi jasay jarilay bolqu:: noqai kösigen-i dotur-a orobasu er-e em-e qoyar qayacaqu bui:: noqai yolomtan-du kebtebesü kümün ükükü:: noqai oron door-a kesün: emün-e maltan üngke(Öngge?)-lebesü mayu bui:: noqai genedte ebecin ükü=besü kele ama ebecin bolqu:: noqai-yin edegebesü ejen-dür qarsi:: noqai-yin nid-n-ece nilbusun cuburibasü nigül qarasi:: noqai siltayan ügei köl ebüdüg-iyen sögüdcü yabubasu ükül ucirqu:: sigül-iyen jayuju yasalbasu em-e kümün-e mayu:: noqai gölügen-iyen idebesü cusun tölegen bui:: noqai qoruqai göregesün-ijayun gertü orojü irebesü kele ama bolqu:: noqai arkiran egüden-tür bayiju qucabasu cidkü üjegdeküi bui:: noqai gerten maltan basa ejen-dür qucabasu todqar bolju busu kümün bolju ?qucimui:: kereg jasal kibesü sayin:: noqai ünege qoni yamay-a basa kebtege temegen-ü degere abirabasü on kiged yesün saradu masi yeke jobulang üjekü:: teyireng-ün kereg kilge: noqai-i manglai sikül-i tülejü busud-tur ög:: noqai ger-ün barayun tege-ece qarayabasü ger-ün ejen jobalang üjekü: Umaran-aca + ecege eke-dü mayu: doruna-aca+ ger-ün em-e-dü

(5r) mayu: emün-e-ece + boyol adal mal aqui-dur mayu:: ügeyirejü teyireng-ün kereg kilge:: mayad sayin:: noqai degesi qandaju qucan ulibasü bayasjiqu:: doroyisi qanduju ulin yajar mayajilabasü tere ger-ün ejen-dür doloyan qonoy-tu ebecin bolqu:: Sara ciyasun-iyar kümün mal kijü bosuyan door-a töge sögem uquju bula:: Umdang ger-ün aliba jüg-ece tülkebesü (ölgebesü?) dom anu tere jüg-ece jayun cayasun jayun yurban moyulcay sabar kijü yaryaju bula:: qoyar bicig jaruju qayaly-a-yin degere nayabasü sayin bui:: noqai uuryan-u quiba-luy-a oroyaldubasu adayu anu ükükü beige: qara baling kümün kijü tere degesün-iyer oroyaju yary-a: morin ba üker qoni yamay-a qayir ög:: noqai kögenen luy-a oroyaldubasu ecege kübegün-ü nigen-dü yai bui:: yul?ir-iyar cayan baling kümün cayan degesün-iyer küljü yarya küren mori, qara üker yamay-a-tur qubacid jolij Ögcü yary-a:: nom öberün sungdui ungsi :: noqai ögerün toru-luy-a oroyaldubasu em-e kümün-dü yai bui baling-i kümün kijü yary-a: tere ükür-i baysi-du ög:: basa noqai genete söni jayatan ama kelen-i doluyaju cikin-iyen sejibesü tere ger ba kümün-dü serebesü mayajabasü nigen tedüi

(5v.) sayin:: Qonin aliba adayusun-a yeke mayu üilen ucaraqu:: Noqai-yin bey-e-yi qara, terigün-i cayan, köl segül-i Sara bögesü büü tejy-e, yeke mayu:: örügesün törübesü mayu, büü tejege:: Basa nigen eketü aliba ükin niyun nidü ügei törübesü büü tejy-e:: aliba mal nidün ügei törübesü büü tejy-e ejen-dür mayu:: Basa aliba mal ni.....? törübesü ejen-dür mayu bui:: nige toluyai-tai qoyar biy-e-tei törübesü sayin:: 1 nidü-tei törü-besü ejen-dür mayu:: nidün ügei ümekei törübesü ejen inü ükül ese bügesü sürüg ügei bolqu:: Basa üker qoni yamay-a ger mörgön yabubasu ejen-dür ükül ucirqu seregü kereg tusatai kereg ki:: Temege genedte buyilabasu sürüg-tü ülü bayilam :: Basa basa irejü yayilbasu ejen-dü yeke yai bui:: Tegün-i jasal ulayan qaljan üker-tü 9 jüil idege: 9 saraq 9 qara cayasun: 9 qara ciluyu: 9 keseg Sara soroi: üker-tür aciju uridu yabuyul: Qonin temege jay suqai tasiyur-iyar ülegdegdekü bolai teyin kibesü masi berke yai nögecikü bolai:: Basa aliba mal-un beyn-ece cisun yarabasLi ejen inü ükükü beige bolai:: mön tere mal-un bey-e egüdcü dotor-a-aca inu cisun debüregül

(6r) -ün nom ungsiju yary-a: aliba adayu-sun nicügen törübesü mayu iru-a mön kereg kilge aliba adayusun dutuyu köl-tei toluyai ügei bey-e ügei qayas toluyai-tai törübesü ejen qayan qatun-u bey-e-nügüd qoyar-un nigen-dü mayu: tegün-i ejen inü öber-ün sayudal oron-u nom kereg kilge tegün-ü baysi-du ög:: aliba adayu-sun oroldubasu tere qoyar adayusun-i yulir-iyar egüdün qoyar suyun-dur cucalai qabcayulju bögsen-dür qubcasun-i nemürgejü ecige ebüge-yin neren-i nerelen ene mayu iru-a-yi ecige ebüge ab kernen yaryaydaqui:: Tere qoyar adayusun-i nom ungsiju baysi-dur minu Öglige kernen ögülejü ög:: Mayu iru-a bolbasu üdtür seregdeküi ::::: :: Sayin amuyulang boltuyai :: : :: : Om sobaran dasda-a bazar-yi suha-a (Om - supra - tistha - vajra - ye - swaha)

Aliba oroyal-duysan mayui iru-a-yi qariyul-qu buu ene bui::

Aliba noqai-yin mayui iru-a-yi qariyulqu buu ene bui::

Ger quduy aliba usun jögökü saba bügüde-yin buu ene bui::

